




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР
НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧИД
2020 ОНЫ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2021 он


АГУУЛГА

- I. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч
 - II. Улсын хилээр орсон гадаадын зорчигч, жуулчид
 - III. Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл
 - IV. Улсын хилээр гарсан дотоодын зорчигч
- Дүгнэлт

I. УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ

Монгол Улсын хилийн боомтоор 2020 онд 1.3 (давхардсан тоогоор) сая зорчигч нэвтэрсэн байна. Нийт хилээр нэвтэрсэн зорчигчдын 81.3 хувь нь эрэгтэй, 18.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Улсын хилээр 2020 онд нэвтэрсэн зорчигчдын тоо 1995 онтой харьцуулахад 24.1 хувиар өссөн бол харин 2010 оноос 64.2 хувь, 2015 оноос 72.9 хувиар, өмнөх оноос 78.4 хувиар тус тус буурчээ. Дараах зургаас харахад 2013-2018 он хүртэл хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо аажим өсөлттэй явж өсөлтийн дээд цэг нь 2018 он байгааг харж болох юм.

Зураг 1. Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчид, мянган хүн, 2010-2020 он




Улсын хилээр орсон зорчигчдын 606.8 (90.1%) мянга нь Монгол Улсын иргэд, 66.9 (9.9%) мянга нь гадаад улсын иргэд байна.

Коронавируст халдвар (COVID-19) дэлхий дахинд гарсантай холбогдуулан Монгол Улсын хилийн боомтуудыг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хааж эхэлсэн. Энэ оны 10-р сард Монгол Улсын 3 531 иргэн тусгай үүргийн нислэгээр, 57 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, 11-р сард Монгол Улсын 605 иргэн тусгай үүргийн нислэгээр, 10 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, 12-р сард Монгол Улсын 541 иргэн тусгай үүргийн нислэгээр, 41 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар тус тус ирсэн байна.

Манай улсын хилээр 2020 онд 673.8 мянган зорчигч орсон нь өмнөх оноос 2.4 (77.9%) саяар буурчээ. Улсын хилээр орсон зорчигчдын 26.3 хувь нь Гашуун сухайт, 23.0 хувь нь Замын-Үүд, 16.4 хувь нь Шивээхүрэн, 14.6 хувь нь Буянт-Ухаа, 7.7 хувь нь Алтанбулаг, 12.0 хувь нь бусад боомтоор орсон байна.


Зураг 2. Монгол Улсын хилээр орсон зорчигчдын тоо, 2020 он



Нийт орсон зорчигчдын 80.3 хувь нь Замын-Үүд, Буянт-Ухаа, Гашуун-Сухайт ба Шивээхүрэн зэрэг 4 том боомтоор орж ирсэн зорчигчид эзэлж байна.

Монгол Улсын хилээр гарсан зорчигчдын 27.4 хувь буюу 176.3 мянган зорчигч Гашуун сухайтаар, 22.5 хувь буюу 144.4 мянган зорчигч Замын-Үүдээр, 17.1 хувь буюу 109.7 мянган зорчигч Шивээхүрэнгээр, 12.7 хувь буюу 81.6 мянган зорчигч Буянт-Ухаагаар 20.3 хувь буюу 130.3 мянган зорчигчид бусад боомтуудаар орж иржээ (Зураг 3).

Зураг 3. Монгол Улсын хилээр гарсан зорчигчдын тоо, 2020 он



Манай улсын хилээр орсон зорчигчдыг аяллын байдлаар авч үзвэл 2020 онд нийт орсон зорчигчдын 2.9 хувь буюу 19.7 мянга нь албан ажлаар, 4.1 хувь буюу 28.0 мянга нь хувийн журмаар, 90.4 хувь буюу 608.8 мянга нь байнга оршин суухаар, 2.6 хувь нь бусад зорилгоор орж ирсэн байна.

Хүснэгт 1. Улсын хилээр орсон зорчигчид, аялалын зорилго, боомтоор, 2020 он

Боомтын нэр	Орсон	АЯЛЛЫН ЗОРИЛГО			
		Албан ажлаар	Хувийн журмаар	Байнга оршин суух	Бусад
Бүгд	673 761	19 738	27 996	608 804	17 223
Алтанбулаг	51 835	1 597	7 432	39 921	2 885
Арц суурь	742	1	246	494	1
Байтаг	-	-	-	-	-
Баянхошуу	9 431	1	82	9 140	208
Бичигт	9 992	8	23	9 556	405
Боршоо	8 956	14	7 433	1 198	311
Булган	12 195	1	10	12 170	14
Бургастай	1 469	2	1 459	1	7
Буянт-Ухаа	98 495	4 143	4 212	82 219	7 921
Гашуунсухайт	177 225	4	192	176 820	209
Даян	-	-	-	-	-
Замын-Үүд	154 848	6 815	1 613	142 256	4 164
Сүмбэр	-	-	-	-	-
Сүхбаатар	9 967	7 134	92	2 202	539
Тэс	111	-	20	91	-
Ульхан	188	-	44	142	2
Хавирга	5 020	8	52	4 878	82
Ханги	9 689	-	22	9 667	-
Ханх	1 963	-	24	1 568	371
Ховд	-	-	-	-	-
Цагааннуур	9 816	10	4 887	4 901	18
Чойбалсан	-	-	-	-	-
Шивээхүрэн	110 410	-	40	110 284	86
Эрээнцав	1 409	-	113	1 296	-

II. УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ЗОРЧИГЧ, ЖУУЛЧИД

Монгол Улсын хилээр 2020 онд 1.3 сая зорчигч орсны 66.9 мянга нь гадаадын зорчигчид байна. Энэ нь өмнөх оноос 89.5 хувь буюу 570.0 мянгаар буурчээ.

Өмнөх онуудад байнга өсөлттэй явж ирсэн бөгөөд 2019-2020 оны хооронд Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор энэ онд огцом бууралттай жил байлаа. Тэдний 87.8 хувь нь 30 хүртэл хоног, 1.7 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 10.5 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна.

Гадаадын зорчигчдын 53.7 хувь нь Европ, 41.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, 2.8 хувь нь Америк, 2.0 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Зураг 4. Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2016-2020 он



19.7 пунктээр буурсан ба харин Европ тивээс ирсэн зорчигчид өмнөх оныхоос 21.1 пунктээр өссөн байна.


Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан бөгөөд энэ нь цар тахал дэгдсэнтэй холбоотой.

Зураг 5. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, жуулчид, сүүлийн 11 жилийн байдлаар, мян.хүн




Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан харвал, 87.9 хувь буюу 58.9 мянга нь аялал жуулчлалын зорилгоор, үлдсэн 12.1 хувь буюу 8.1 мянга нь ажиллах, суралцах, байнга оршин суух гэсэн урт хугацааны зорилгоор иржээ.

Зураг 6. Жуулчдын тоо, улирал, сүүлийн 5 жилийн байдлаар, мян. хүн



Монгол Улсад ирсэн нийт жуулчид 2016-2019 оны дунджаар 68.6 хувь нь II, III дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирдэг нь дээрх зургаас харагдаж байна. Өвлийн улиралд ирэх жуулчдын тоо бага байгаа нь манай орны цаг уурын байдал хатуу ширүүн болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэргээс шалтгаалсан байх магадлалтай.

Зураг 6. Жуулчдын тоо дүнд эзлэх хувиар, улсаар, 2020 он



Монгол Улсад 2020 оны байдлаар ирсэн жуулчдыг дүнд эзлэх хувиар авч үзвэл 50.3 хувийг ОХУ-аас ирсэн жуулчид, 23.0 хувийг БНХАУ-аас ирсэн жуулчид, 8.6 хувийг БНСУ-аас ирсэн жуулчид, 3.6 хувийг Беларусуаас ирсэн жуулчид, 2.6 хувийг Казахстануаас ирсэн жуулчид, 1.9 хувийг Япон, АНУ-аас ирсэн жуулчид, 1.0 хувийг ХБНГУ-аас ирсэн жуулчид, үлдсэн 7.1 хувийг бусад улсаас ирсэн жуулчид тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Улсын хилээр орсон гадаад зорчигчид, бүс нутаг, улсаар

	2017	2018	2019	2020
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	345 648	372 876	389 581	27 806
БНХАУ	201 912	216 379	208 449	17 340
БНСУ	76 637	86 013	10 3379	5 515
Казахстан	23 093	21 621	25 163	1 564
Европ	164 403	189 161	207 851	35 931
ОХУ	110 353	133 402	146 783	30 980
Беларусь	10 777	11 015	12 654	2 338
ХБНГУ	10 154	9 909	10 716	641
Америк	24 096	25 767	27 174	1 862
АНУ	17 663	18 866	19 948	1 416
Канад	4204	4481	4501	320
Бразил	745	792	900	34
Өмнөд Ази	3 127	3 909	4 381	296
БНЭУ	2 082	2 572	2 793	236
Иран	230	349	416	19
Балба	255	304	337	13
Ойрх Дорнод	3 977	4 806	5 453	620
Турк	2 262	2 779	1 999	573
Израил	911	945	1158	20
Катар	228	422	866	11
Африк	1 416	1 848	2 480	422
Өмнөд Африк	928	1 218	1 764	299
Гана	54	55	72	10
Кени	50	67	58	9
Харьяалалгүй	36	39	37	3
Нийт	542 703	598 406	636 960	66 940


Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 2020 онд 64.7 (96.7%) мянга нь насанд хүрсэн хүн, 2.2 (3.3%) мянга нь хүүхэд, 50.9 (76.1%) мянга нь эрэгтэйчүүд, 16.0 (23.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 53.8 хувь нь Европ, 41.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг, 2.8 хувь нь Америк, 1.9 хувийг Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 46.3 хувийг ОХУ-ын иргэд, 25.9 хувийг БНХАУ-ын иргэд, 8.2 хувийг БНСУ-ын иргэд, 3.5 хувийг Беларусь, 2.3 хувийг Казахстан, 2.1 хувийг АНУ-ын иргэд, 11.6 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Монгол Улсад урт хугацааны зорилгоор буюу ажиллах, суралцах, байнга оршин суухаар ирсэн 8.1 мянган гадаадын зорчигчдын 47.4 хувь нь БНХАУ-аас, 16.6 хувь нь ОХУ-аас, 6.6 хувь нь Австрали улсаас, 5.6 хувь нь БНСУ-аас, 3.3 хувь нь АНУ-аас, үлдсэн 20.5 хувь нь бусад улс орноос ирсэн иргэд эзэлж байна. 2020 онд ОХУ, Австрали, БНСУ, АНУ, бусад улсаас ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын дүнд эзлэх хувь өмнөх оноос 0.9-7.0 пунктээр өссөн байна. Харин БНХАУ улсаас урт хугацааны зорилгоор ирсэн гадаадын зорчигчдын дүнд эзлэх хувь өмнөх оноос 19.9 пунктээр буурчээ (Зураг 8).


Зураг 8. Ажиллах, суралцах, байнга оршин суух зорилгоор ирсэн гадаадын зорчигч, улсаар, 2019, 2020 он



III. УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Улсын хилээр 2020 онд 1.8 (давхардсан тоогоор) сая тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 81.0 (4.4%) мянгаар буурчээ. Тэдгээрийн 51.6 хувийг ачааны вагон, 43.2 хувийг ачааны машин, 3.8 хувийг суудлын машин, 1.4 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Зураг 9. Монгол Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, 2020 он



Нийт тээврийн хэрэгслийн 47.4 хувь нь Замын-Үүд, 19.2 хувь нь Гашуун сухайт, 12.1 хувь нь Шивээ хүрэн, 2.4 хувь нь Алтанбулаг, 13.1 хувь нь Сүхбаатар, 5.8 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна

IV. УЛСЫН ХИЛЭЭР ГАРСАН ДОТООДЫН ЗОРЧИГЧ

Манай улсын 571.9 (давхардсан тоогоор) мянган иргэн 2020 онд гадаадад зорчсоноос 268.9 (47.0%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оноос 1.7 (86.3%) саяар, 302.9 (53.0%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь 146.1 (32.5%) мянгаар тус тус буурчээ. Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 475.0 (83.1%) мянга нь эрэгтэйчүүд, 96.8 (16.9%) мянга нь эмэгтэйчүүд, 12.7 (2.2%) мянга нь хүүхэд байна.

Гадаадад зорчсон Монгол иргэдийн 81.7 хувь нь БНХАУ-руу, 8.5 хувь нь ОХУ-руу, 3.2 хувь нь БНСУ-руу, 1.1 хувь нь Япон улс руу, үлдсэн 5.5 хувь нь бусад улс орнууд руу зорчжээ. Тэдний 555.6 (97.1%) мянга нь 30 хүртэл хоног, 3.7 (0.7%) мянга нь 90, түүнээс дээш хоног, 12.6 (2.2%) мянга нь 30-аас 90 хүртэл хоногийн хугацаагаар явсан байна.

Зураг 10. Гадаадад зорчсон Монгол иргэд, улс, хувиар, 2020 он



Хилээр гарсан дотоодын зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 30.7 хувь нь Гашуун сухайт, 23.2 хувь нь Замын-Үүд боомтоор, 19.1 хувь нь Шивээхүрэн, 10.6 хувь нь Буянт-Ухаа, 6.2 хувь нь Алтанбулаг, 10.9 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

ДҮГНЭЛТ

- ✈ Манай улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байсан хэдий ч 2019-2020 онд Дэлхий нийтэд нүүрлэсэн Ковид-19 цар тахал тархсантай холбоотойгоор 2020 онд огцом буурлаа. Улсын хилээр 2009 онд 3.0 сая зорчигч нэвтэрч байсан бол 2019 онд 6.1 сая болж 2 дахин нэмэгдсэн байна.
- ✈ Сүүлийн 10 жилийн хугацаанд гадаадад зорчих Монгол иргэдийн тоо хурдацтай нэмэгдэж байна. Улсын хилээр 2020 онд нэвтэрсэн нийт зорчигчдын 673.8 мянга нь дотоодын зорчигчид байсан ба үүнийг 2019 онтой харьцуулахад 77.9 хувиар буурлаа.
- ✈ Хилээр орсон 1.3 сая зорчигчийн 66.9 мянга нь гадаадын иргэд бөгөөд 2010 онтой харьцуулахад 88.0 хувиар, өмнөх оноос 89.5 хувиар тус тус буураад байна.
- ✈ Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 8.7 хувь буюу 58.9 мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн нь 2010 онтой харьцуулахад 87.1 хувь, өмнөх оноос 89.8 хувиар тус тус буурчээ.
- ✈ Монгол орныг зорих жуулчдын тоо сүүлийн 11 жилд бага өсөлттэй байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал:
 - ⊖ Манай орны цаг агаарын байдал, ялангуяа жуулчлал хийх дулаан, таатай улирлын хугацаа богино байна. Монгол Улсад ирж буй нийт жуулчдын 68.6 хувь нь дулааны улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд ирдэг.
 - ⊖ Манай улсын болон ялангуяа жуулчны бааз, отогийн дэд бүтцийн хөгжил муу,
 - ⊖ Монгол улсад ирж, очих агаарын нислэг хязгаарлагдмал, тийзний үнэ өндөр,
 - ⊖ Төв суурин газрын агаар, хөрсний бохирдол их.
 - ⊖ Манай оронд өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй, жуулчдыг татах өвлийн арга хэмжээ бага байдаг.

Манай улс нүүдлийн соёл, уламжлалаараа жуулчдыг татахыг эрмэлзлэлээ улам бүр өргөжүүлэн Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татах үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна. Юуны түрүүнд Засгийн газраас хүн ая тухтай аялахад шаардлагатай наад захын нөхцөл буюу дэлхийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж, дэд бүтцийг эрс шинэчлэн сайжруулах хөтөлбөрийг даруй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Аялал жуулчлалын тухай хууль 2000 он

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр 2015 он

Төрийн мэдээлэл, Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар, 2020 он

Үндэсний Статистикийн Хороо www.1212.mn

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТОВЧОО

Боловсруулсан: Ж.Цогзолмаа /ҮСХ-ны ХАНСГ-ын ХАОСТТ-ны статистикч/